

21. Аав аа, манай АНУ-ын дотоод оффис хойч үедээ хүрч ажиллаж байгаа тул энэ бүлгийн хүсэл тэмүүлэлтэй гишүүдтэй ойртож, тэднийг TWR-ийн “Найдвар Доторх Эмэгтэйчүүд” номлолд татан оролцуулах мэргэн ухааныг манай баг өгөөч. (Дуу. 145:4)

22. Эзэн минь, Бонайр дахь яамны удирдагчдыг төрөлх хэл болох Папиаменту хэлээр шүлэг, магтаалын дууны цуглуулга эмхэтгэх үед тэдэнд эрч хүч, тэсвэр тэвчээрийг өгөөч. (Евр. 12:1)

23. Аав аа, Аргентин дахь залуу эмэгтэйчүүд Есүстэй ойр дотно алхаасай гэж бид залбирч байна. Эдгээр залуу эмэгтэйчүүдэд хүрч, тэдэнтэй сайн мэдээг хуваалцахын тулд бусад итгэгчдийг ашиглаач. (Кол. 2:6)

24. Уругвайд залуу охид, эмэгтэйчүүдийн дунд гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл их байдаг. Эзэн минь, бид “Найдвар Доторх Эмэгтэйчүүд” хөтөлбөрүүд Христ Есүс дотор эмэгтэйчүүдийг үргэлжлүүлэн хүчирхэгжүүлээсэй гэж гуйж байна. (Дэд хууль 31:6)

25. Хүндэт аав аа, TWR-ийн бүс нутгийн яам болон манай Парагвайн үндэсний түнштэй хамтран ажиллаж буй багуудад өөрсдийн огтлолцсон радио сүлжээнд цацагдаж буй нэвтрүүлгүүдийн хүрээг өргөжүүлэхэд туслаач. (Үйлс 13:49)

26. Эзэн минь, Бразилийн бага орлоготой эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн үндсэн тусламж үйлчилгээний нэг хэсэг болгон эрүүл ахуйн зайлшгүй шаардлагатай зүйлсээр хангаасай гэж бид залбирч байна. (Дуу. 68:10)

27. Төгс Хүчит Бурхан минь ээ, эрх баригчдаас Латин Америкийн бүс нутаг болон Карибын тэнгисийн орнуудад жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх, бэлгийн хүчирхийллийн эсрэг тууштай тэмцээсэй гэж бид хүсэж байна. (1Тим. 2:1-4)

28. Эзэн минь, Испани, Латин эмэгтэйчүүд танд болон тэднийг нийгэмд ямар их үнэ цэнэтэй гэдгийн мэдрүүлээч. Оюун ухаан, бие, сэтгэл хөдлөлөө бэхжүүлж, Тэд танд бүрэн захирагдах болтугай. (Ефес 1:3-5)

후원안내
국민은행 851-01-0003-724 북방선교방송
최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다



Найдвартай
ЭМЭГТЭЙЧҮҮД

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



2022. 2.

Хойд Америкийн эмэгтэйчүүдийн төлөөх залбирал.

Америк тивийн эмэгтэйчүүд нь амьдралд маш олон зүйл дээр сорилтонд орж байна. Эрэгтэй хүмүүстэй харьцуулахад тэгш бус цалингийн хэмжээ, байнга үргэлжлэх дарамт зэрэгт ихээр өртдөг. Олон эмэгтэйчүүд их дээд сургуулиас дээгүүр боловсрол эзэмшсэн ч, эсрэгээрээ боловсрол эзэмших боломж нь ч олддоггүй эмэгтэйчүүд маш ихээр байсаар байна. Та бүхэн Америк тивийн охид бүсгүйчүүдэд боловсрол эзэмших боломж олдож, нийгэмд эрэгтэй хүмүүстэй эрх тэгш хүндлэгдэн амьдрах өдөрийн төлөө залбирч өгөхийг гуйж байна.

TWR Korea 북방선교방송

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr

1. Эзэн минь, Испани хэл дээрх “Найдвар Доторх Эмэгтэйчүүд” хөтөлбөр 21 жилийн ойгоо тэмдэглэж байна. Америк даяар радио, интернет, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан тархаж байгаад таньдаа маш их талархаж байна. (Ис. 55:11)

2. Эзэн минь ээ, бид хүчирхийллийн улмаас Мексикт алга болсон эмэгтэйчүүдийн төрөл төрөгсөдтэй хамт хашгарч байна. Эдгээр Хамаатан саданы шаналал, санаа зоволтийн авч тайвшруулж, хүчирхэгжүүлээч. (Дуу. 23:4)

3. Хүндэт Бурхан минь ээ, бид таны үнэ цэнэ, мөн чанарыг ойлгохгүй байгаа Колумбын залуу эмэгтэйчүүд, охидын төлөө залбирч байна. Тэд таныг хүлээн зөвшөөрч, үгийг тань сурч, таны бодсон, төлөвлөсөн зүрх сэтгэлтэй, сайхан эмэгтэйчүүд болоосой гэж хүсэж байна. (Эх. 1:27)

4. Бурхан минь, бид Перугийн эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээний ач холбогдлыг ойлгож, энэ талаарх боловсрол эзэмшээсэй гэж хүсч байна. (1Кор. 6:19–20)

5. Эзэн минь ээ, бид Бүгд Найрамдах Доминиканы Улсад ядуу бүлэгт байдаг эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хүүхдүүд, өндөр настангуудад гэр бүлийн анхаарал халамж, засгийн газраасаа тэтгэмж ч авч чадалгүй амиа алдаж байгаа хүмүүсийн төлөө залбирч байна. (Дэд хууль 15:7–8)

6. Бурхан минь, Канад дахь яамдад шинэ түншлэл бий болгож, тэнд байгаа эмэгтэйчүүдийн сүнслэг, бие махбодь, сэтгэл санааны хэрэгцээг хангах боломжоор хангаасай гэж бид танаас хүсч байна (Гал. 6:9).

7. Парагвайн баг шинэ ордонд үйлчлэлээ эхлүүлж, ял эдэлж буй хоригдлууд тухайн орчиндоо тодорхой эрх чөлөөг эдэлж байгаад Бурхан минь танд баярлалаа. (Ис. 61:1)

8. Хүндэт Бурхан минь ээ, Кубын өрх толгойлсон эхчүүдэд улс орныхоо эдийн засгийн хямрал, хүнд хэцүү үеийг давж гарах хүч чадал мөн гэр бүлээ халамжлах мэргэн ухааныг хайрлаач. (Дуу. 119:66)

9. Эзэн Бурхан минь, Бонайрийн хүн ам өсөхийн хэрээр тэднийг бие биедээ хүлцэнгүй хандаж, хамтран ажиллахдаа харилцан хүндэтгэлтэй байхад нь туслаач. Тэд таныг үлгэр дуурайлал болгон харах болтугай. (Мат. 7:12)

10. Хүндэт аав аа, бид цагаач гэр бүлийн охидыг хоёр соёл иргэншил дотор нэгэн зэрэг амьдрахын төлөөх тэмцэлдээ тэнцвэртэй байдлыг олж авах болтугай гэж хүсч байна. Тэд Христ дотор амар амгаланг олох болтугай. (Флп 4:6-7)

11. Эзэн минь, Бразилд Христэд итгэгчдийн гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах хоргодох байр улам олон болоосой гэж залбирч байна. Тэр газар эмэгтэйчүүд болон гэр бүлүүд Есүсийг таньж мэдэх аюулгүй газар байх болтугай. (Дуу. 46:1)

12. Аав аа, Латин Америкт 1.5 сая орчим залуучууд сургуульд сурч чадахгүй байна. Эрх мэдэлтэй хүмүүсийн зүрх сэтгэлийг зөөллөж, боловсролыг нэн тэргүүнд тавихад нь туслаач. (Сур. 18:15)

13. Эзэн минь, Уругвайн олон эмэгтэйчүүд өдөр бүр радиогоор цацагддаг эдгээр залбирлын хүсэлтийг сонсож, эсвэл интернетээс уншиж байхдаа орой бүр залбирахаар цугларч байгаад бид таныг магтъя. (Иер. 29:12)

14. Эзэн минь, ээжийг нь хөнөөсөн эсвэл эцэг эх нь амиа хорлосны улмаас өнчирч хоцорсон хүүхдүүдийг тэтгэж өгөөч. (Дуу. 10:14)

15. Төгс Хүчит Их Эзэн минь, та Бүгд Найрамдах Доминикан улсад хоригдож буй эмэгтэйчүүдэд сайн мэдээг сонсох үүд хаалгыг нээж өгөөч. Тэд бие махбодийн хувьд хоригдож байсан ч танаас эрх чөлөө, сэргэлтийг олж авах болтугай. (Иохан 8:36)

16. Аав аа, Колумбидах эмэгтэйчүүдийг өршөөгөөч, эмэгтэй хүний амь насыг хөнөөх явдал ихсэж байгаа бөгөөд тус улсын алслагдсан бүс нутагт алуурчдыг үр дүнтэй саатуулах хүчин чадал бага, шүүхийн нарийн төвөгтэй тогтолцоо байдгаас байдал улам бүр дордож байна. (Ис. 49:13)

17. Эзэн минь, итгэгчдийн зүрх сэтгэлд сүнслэг мэдрэмж, энэрэн нигүүлслийг авчираач, тэд Латин Америк дахь COVID-19 өвчтэй хүмүүст үйлчлэх болтугай. (1Иохан 3:17)

18. Аав аа, Парагвайн хөдөө орон нутгийн залуу эмэгтэйчүүд албан ёсны сургалт, боловсрол эзэмших нөхцөл боломжийг олгооч гэж бид залбирч байна. (Сур. 4:13)

19. Аав аа, Доминиканы Бүгд Найрамдах Улс дахь TWR “Найдвар Доторх Эмэгтэйчүүд” –ийн итгэл найдварын ажилд оролцож буй хүмүүст идвэхтэй үйлчилж, бичиж, оролцоход нь хүч чадал, бүтээлч байдлаа өгөөч. (Ис. 40:31)

20. Эзэн минь, Латин Америкийн орнуудад гэр бүл, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настны эсрэг хүчирхийллийг таслан зогсоогооч гэж бид нэгдэн залбирч байна (2 Сам. 22:3-4).